

**“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

(2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.11.23

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан 1 зорилтын 2 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

2022 оны жилийн эцсийн байдлаар зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр **“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90.0 хувьтай** байна.

5.2.18. Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ. **Үр дүн – 90.0 хувь:**

- **Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьсан. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн;

5.2.19. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна. **Үр дүн – 70.0 хувь:**

- **Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эхлүүлэх:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолоор нэр бүхий 25 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжиж, олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан. “Төрийн банк” ТӨХХК-ийн хувьд холбогдох эрх бүхий байгууллагуудын шийдвэрүүд гарч, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд арилжаалах ажлыг эхлүүлсэн бөгөөд анхдагч арилжаа амжилттай зохион байгуулагдсан.

**Гурав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/**

- Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хоёр мянган (2000) тэмдэгтэд багтаан тайлагнаж байх;
- Холбогдох хэлтсүүд зорилт, арга хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**

~~Хянасан.~~

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА **Н.ГАНБОЛД**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
МЭРГЭЖИЛТЭН **Д.ЦЭРЭНЛХАМ**